



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; <http://www.city.audit.mn>

2016.03.04 № 290
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн Аудитын газрын захиалгаар "Баянташаагийн эх Аудит" ХХК аудит хийв.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын удирдлага тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэл /УСНББОУС/ түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

"Баянташаагийн эх Аудит" ХХК нь Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

"Баянташаагийн эх Аудит" ХХК нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ



БАЯН ТАШААГИЙН ЭХ
АУДИТ ХХК

Нийслэлийн Соёлолчлалын Газар

ХХК-ийн 12 дугаар хороо, ЗГ-ийн ордон, Зүүн талд байр болон өмчлөх, төс
снийг үйлдвэрлэх газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14101 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2016.03.04 № 290
талай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ
ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн Аудитын газрын захиалгаар "Баянташаагийн эх Аудит" ХХК аудит хийв.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын удирдлага тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэл /УСНББОУС/ түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

"Баянташаагийн эх Аудит" ХХК нь Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

"Баянташаагийн эх Аудит" ХХК нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

1110000000

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




Ц.ОЧИРБАТ



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Я.Самбууням
Утас: 327734
Санхүүгийн аудитын
Менежер
Д.Энхдалай
Утас: 315558

Баянташаагийн Эх Аудит
ХКомпаний захирал: Хоролсүрэн
Утас: 99062255
Цахим хаяг: moogii9809@yahoo.com

БТЭ -ын хаяг: Баянгол дүүрэг
2-р хороо HILLSIDE хотхон
С-ийн 123 тоот

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаархи дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газрын захиалгаар "Баянташаагийн эх Аудит" ХХК /НАГ-АХ-2016/-ГАК-НСУГ-11/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь "Баянташаагийн эх Аудит" ХХК-ийн үүрэг юм.

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны санхүүгийн тайлангийн завсарын аудитыг 2015 оны 12 дугаар сарын 22-нөөс 12 сарын 31-ний хооронд санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 2 дугаар сарын 28-ны хооронд хийхээр төлөвлөн "Баянташаагийн эх Аудит" ХХК-ийн аудитор М.Тэнгис, Ч.Чимгээ нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Нийслэлийн Соёл урлагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланг 2015 оны 01 дүгээр сарын 25-нд "Баянташаагийн эх Аудит" ХХК -д ирүүлсэн байна.

Нийслэлийн Аудитын газартай хийсэн гэрээний дагуу "Баянташаагийн Эх Аудит" ХХК аудитыг 2015 оны 12 дугаар сарын 22-нөөс 2016 оны 3 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 03 дугаар сарын 4-нд Нийслэлийн Соёл урлагийн газрын удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга нь "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Соёлын тухай" хуулиуд болон холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Нийслэлийн Соёл Урлагийн Газар нь "Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах, соёлын үнэт зүйлийг өвлүүлэн эзэмшүүлэх, тэдгээрийг сурталчлах, иргэдийн уран сайхны боловсрол, нийтийн соёлыг дээшлүүлэх, соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулах" гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны төсвийн санхүүжилтийг Нийслэлийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн Соёл урлагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Соёл урлагийн газрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Нийслэлийн Соёл урлагийн газар нь санхүүгийн үйл ажиллагаагаа програмаар боловсруулж байгаа бөгөөд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдалд үнэлгээг хийхэд бага эрсдэлтэй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Соёл урлагийн газар санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах явцаа санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Соёл урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон, нягтлахад үйл ажиллагааны дотоод хяналт хангалттай биш байлаа. ААНБайгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Соёл урлагийн газар нь 2015 онд урсгал зардалд 218,560.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөгдөж, урсгал төсөвт 213,368.0 мянган төгрөгийн санхүүжилт, Засаг даргын төсвөөс хөтөлбөрийн санхүүжилт 2,179,561.1 мянган төгрөгийн санхүүжилт, хураамжийн орлого 2,840.0 мянга, музейн тооллогын зардал 450.0 мянган төгрөг, тайзны түрээсийн орлого 30,271.2 мянган төгрөгийн орлого олж нийт 2,426,491.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Үүнээс 165,359.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,206,145.7 зарцуулж, оны эцэст 54,986.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, батлагдсан төсвөөс 53,201.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2015 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан (таван сая төгрөгөөс дээш үнийн дүн

бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийг нягтлан бодогч О.Одхүү хариуцан гаргадаг.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитаар Нийслэлийн Соёл урлагын газраас 2015 онд томоохон хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулахдаа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаггүй шууд гэрээ байгуулдаг, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан, Нийслэлийн төр захиргааны авто баазаас дуудлагын автомашины хэрэглээний зардлыг бүлгийн дүнгийн төсвөөс хэтрүүлэн зарцуулсан зөрчлүүд илэрлээ. Эдгээр зөрчлүүд нь төсвийг үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомжуудыг зөрчих, нягтлан бодох бүртгэлийн заавар журмыг хэрэгжүүлэхгүй байх сөрөг үр дагаварт хүрч болзошгүй юм.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, бусад орлого, халаалт, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, холбооны зардал, тээврийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90 хувь, мөнгөн хөрөнгийн 85 хувь, нийт зардлын 84.5 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

1. **“Нийслэлийн шинэ жилийн баяр”** арга хэмжээг зохион байгуулах 79,644.2 мянган төгрөгийн хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт зарлаагүй “Эл И Ди” ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1 *“техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдээгдэх”* заалтыг хэрэгжүүлээгүй байна.

- **Шийдвэрлэсэн:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг байгууллагын удирдлагын зүгээс хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

2. Малайз улсын Кота Кинабалу хотноо "Жи Си Ай" олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Ази, номхон далайн орнуудын чуулга, уулзалт"-ын үеэр зохиогдсон Улаанбаатар хотыг сурталчлах, соёл урлагийн тоглолтод оролцсон уран бүтээлчдэд олгосон зочид буудлын зардал 2,880.0 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1, 20.1.7 заалтуудыг зөрчиж байна.

- Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, санхүүгийн тайланд тусгахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

3. Нийслэлийн төр захиргааны авто баазаас хэрэглэсэн дуудлагын автомашины зардал, хангамж бараа материалын зардлыг 2,294.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. заалтыг зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж өгснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрч цаашид зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар санхүүгийн тайланд илэрсэн хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 84,819.1 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Нийслэлд хэрэгжүүлж байгаа соёл, урлагийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаггүй, шууд гэрээ байгуулдаг асуудал нь холбогдох хууль, тогтоол, журам, зааврыг хэрэгжилт хангагдахгүй байх томоохон эрсдэл дагуулж байгаа тул цаашид анхаарч ажиллах нь зүйтэй. Хангамжийн материал 529,716.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь "Даншиг наадам" хөтөлбөр "Цөмөөхэй бүжгийн жүжиг" хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн цамын хувцас, бүжгийн жүжгийн хувцас хэрэгслийг НӨХГ-ын шийдвэрийн дагуу Нийслэлийн Соёл урлагийн газрын данс бүртгэлд орлого авснаас шалтгаалж өссөн байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн завсарын аудитаар хөтөлбөр, арга хэмжээний зардлуудын хэрэгжилт үр дүнг нягтлан шалгах болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 84,819.1 мянган төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг Нийслэлийн аудитын газраас хийж, өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд тусгасан, шатахууныг бараа, материалын тайланд тусгаагүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй зарлагадсан, цалин хөлс, тээврийн хөлсний үүссэн тооцоог тухай бүрд нь журналд бичилгүй, улирлын эцэст бөөн дүнгээр тусгаж дансны бичилт буруу хийсэн зөрчлүүд байсныг зөвлөмжийн дагуу зөрчлүүдийг арилгаж цаашид мөрдлөг болгон ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт


Нийслэлийн Соёл урлагийн газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ...хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА  Я.САМБУУНЯМ

САНХҮҮГИЙН АУДИТЫН
МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

БАЯНТАШААГИЙН ЭХ АХДИТ
КОМПАНИЙ ЗАХИРАЛ  Т.ХОРОЛСҮРЭН

БЭЛТГЭСЭН: ТАШАА АУДИТОР  Ч.ЧИМГЭЭ

УРЧ01930 0100002



НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт 2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2
Зардал 2

2016 оны 03 дугаар сарын 06

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн Соёл урлагийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

"Баянташаагийн эх аудит" ХХК-ийн энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Соёл урлагийн газрын дарга Б.Батцэнгэл, нягтлан бодогч О.Одхүү нарт талархал илэрхийлье.

Аудитын зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилтийн талаарх хариуг 2016 оны 05 дугаар сарын 30-ны дотор "Баянташаагийн Эх Аудит" ХХК-д ирүүлнэ үү.

Асуудал 1: Үйл ажиллагааны бус орлого	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------------------	---------------------------

Аудитын компанийн ажиглалт

1. **“Нийслэлийн шинэ жилийн баяр”** арга хэмжээг зохион байгуулах 79644.2 мянган төгрөгийн хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулалт, харьцуулсан судалгаагүйгээр “Эл И Ди” ХХК-тай шууд гэрээ байгуулж ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1 *“техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх”* заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.

Эрсдэлүүд

- Төсвийг үр ашиггүй зарцуулах;
- Ашиг, сонирхлын зөрчил үүсэх;
- Төсвийн хөрөнгө хяналтгүй зарцуулагдах.

ААГ-ын зөвлөмж

- ТБОНӨХБАУХАТ хуулийг хэрэгжүүлж ажиллах
- Гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээг дүгнэж ажиллах, улмаар Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг хэрэгжүүлж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

Асуудал 2: Зардал	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------	---------------------------

Аудитын компанийн ажиглалт

1. Малайз улсын Кота Кинабалу хотноо “Жи Си Ай” олон улсын байгууллагаас зохион байгуулсан “Ази, номхон далайн орнуудын чуулга, уулзалт”-ын үеэр зохиогдсон Улаанбаатар хотыг сурталчлах, соёл урлагийн тоглолтод оролцсон уран бүтээлчдэд олгосон зочид буудлын 2,880.0 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1. *“Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно.”*, 20.1.7. *“анхан шатны*

Зөвлөмж

- Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгах байх;

баримт бүрдүүлээгүй ... байх;" заалтыг зөрчиж байна.

2. Нийслэлийн төр захиргааны авто баазаас хэрэглэсэн дуудлагын автомашины зардлыг 2,718.7 мянган төгрөгөөр, бүлгийн зардал болох хангамж бараа материалын зардлыг 880.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаас 2,294.9 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчсөн байна.

- Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах;

Эрсдэлүүд


- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах;
- Холбогдох хууль, журам, заавар хэрэгжихгүй байх;

Төсвийн захирагчийн хариу

- Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч цаашид давтан гаргахгүй анхаарч ажиллах талаар хариу ирүүлсэн.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

НАГАЗРЫН САНХҮҮГИЙН ОРЛОГЧ ДАРГА  Я.САМБУУНЯМ

САНХҮҮГИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

БАЯНТАШААГИЙН ЭХ АУДИТ
КОМПАНИЙ ЗАХИРАЛ  Т.ХОРОЛСҮРЭН

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ч.ЧИМГЭЭ

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ			0
310201	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		0
АВЛАГА			44,177.00
3301	Бусад бэлэн мөнгө		44,177.00
БАРАА МАТЕРИАЛ		39,390,262.00	569,106,562.00
3501	Түүхий эд материал	29,901,900.00	29,901,900.00
3504	Хангамжийн материал	9,488,362.00	539,204,662.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		39,390,262.00	569,150,739.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		32,155,644.95	27,501,097.32
Биет хөрөнгө		32,155,644.95	27,501,097.32
39020101	Барилга, байгууламж	24,000,000.00	24,000,000.00
39020102	Хуримтлагдсан элэгдэл	(9,000,000.00)	(10,800,000.00)
39020301	Машин, тоног төхөөрөмж	230,427,304.20	232,026,304.20
39020302	Хуримтлагдсан элэгдэл	(228,184,695.85)	(230,067,526.44)
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,512,389.09	29,512,389.09
39020402	Хуримтлагдсан элэгдэл	(14,599,352.49)	(17,170,069.53)
39300	Биет бус хөрөнгө	-	-
39030101	Програм хангамж	150,000.00	150,000.00
39030102	Хасагдуулга	(150,000.00)	(150,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		32,155,644.95	27,501,097.32
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		71,545,906.95	596,651,836.32
Богино хугацаат өр төлбөр			2,294,906.18
	Өглөг		2,294,906.18
410306	Бусад өглөг		2,294,906.18
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	2,294,906.18
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН			2,294,906.18
5101	Засгийн газрын оруулсан капитал	261,759,011.80	261,759,011.80
510301	Өмнөх үеийн үр дүн	(190,865,499.41)	(190,865,499.41)
510302	Тайлант үеийн үр дүн		522,811,023.19
5104	Дахин үнэлгээний зөрүү	652,394.56	652,394.56
51600	Нөөцийн сан		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН/		71,545,906.95	594,356,930.14
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН		71,545,906.95	596,651,836.32

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
	Улсын төсвөөс	660,257,600.00	2,395,769,100.00
1303010	Урсгал	188735000	213,368,000.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	471,522,600.00	2,182,401,100.00
1303011403	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах	471522600	2,179,561,100.00
1303011405	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллгааны орлого		2,840,000.00
	Бараа үйлчилгээний орлого	24,355,075.00	111,092,445.26
14020101	Төсөвт байгууллагаас	11370000	450,000.00
140020+140	Бусад орлого	172875	30,272,445.26
	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	12,812,200.00	80,370,000.00
1402010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12812200	80,370,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	684,612,675.00	2,506,861,545.26
2201	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	682,434,268.79	1,925,555,131.30
21	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	130,597,965.00	138,216,249.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	120,024,416.00	124,201,349.00
210101	Цалин	120,024,416.00	124,201,349.00
2102	Нийгмийн хамгаалалын шимтгэл	10,573,549.00	14,014,900.00
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	8,824,350.00	11,510,303.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,075,150.00	8,981,131.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	700,000.00	653,028.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	874,600.00	1,252,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	174,600.00	623,844.00
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	1,749,199.00	2,504,597.00
	Хангамж бараа материалын зардал	15,178,769.00	11,750,077.04
210101	Бичиг хэргийн материал	1,314,300.00	156,500.00
210402	Тээвэр шатахууны зардал	6,837,997.00	7,645,345.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,835,172.00	3,033,232.04
210604	Урсгал засвар	3,846,300.00	915,000.00
	Дотоод албан томилолт	348,000.00	
	Дотоод албан томилолт	348,000.00	
22010315	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	517,903,145.00	1,768,004,035.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	517,903,145.00	1,768,004,035.00
220103	Бараа үйлчилгээний бусад зардал	18,754,389.79	7,584,770.26
210801	Бусад зардал	3,722,233.00	1,222.63
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын	417,500.00	1,330,000.00

	зардал		
22010322	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,614,656.79	6,253,547.63
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,323,213.00	58,495,390.77
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,812,200.00	54,986,262.77
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,812,200.00	54,986,262.77
	Бусад урсгал шилжүүлэг	4,511,013.00	3,509,128.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,511,013.00	3,509,128.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	699,757,481.79	1,984,050,522.07
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(15,144,806.79)	522,811,023.19
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(15,144,806.79)	522,811,023.19

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	660,257,600.00	2,395,769,100.00
	Улсын төсвөөс	223,735,000.00	213,368,000.00
13030101	Урсгал	188,735,000.00	213,368,000.00
1301+1302	Тусламжийн орлого	35,000,000.00	
	Нэмэлт санхүүжилтийн орлого	436,522,600.00	2,182,401,100.00
1303011401	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив		
1303011403	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах		2,179,561,100.00
1303011404	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	436,522,600.00	
1303011405	Төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		2,840,000.00
13030115	Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт		
	Бараа үйлчилгээний орлого	24,355,075.00	30,721,222.63
1402	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	24,355,075.00	30,721,222.63
14020101	Төсөвт байгууллагын үндсэн үйлийн ажиллагааны орлого	11,370,000.00	450,000.00
14020102	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	172,875.00	
140020	Бусад орлого	12,812,200.00	30,271,222.63
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	684,612,675.00	2,426,490,322.63
	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,227,965.00	2,365,435,931.86
	Ажиллагчидтай холбогдсон зардал	131,227,965.00	137,300,426.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,222,465.00	122,887,926.00

210101	Цалин	118,222,465.00	105,446,124.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		10,850,602.00
210104	Үр дүнгийн урамшил		6,591,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	13,005,500.00	14,412,500.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,005,500.00	14,412,500.00
Бараа үйлчилгээний урсгал зардал		536,218,247.00	2,228,136,728.49
220103	Хангамж, бараа материалын зардал	11,108,369.00	7,385,742.86
210401	Бичиг хэрэг	1,663,200.00	1,252,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,037,997.00	4,036,784.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,407,172.00	2,041,058.86
210404	Ном хэвлэл	-	55,000.00
Дотоод албан томилолт		345,000.00	-
	Дотоод албан томилолт	345,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал		5,054,800.00	1,021,000.00
	Жижиг эд хогшил худалдан авах	192,500.00	
210604	Урсгал засвар	4,862,300.00	1,021,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		511,696,200.00	2,217,998,763.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	511,696,200.00	2,217,998,763.00
Бараа үйлчилгээний бусад зардал		8,013,878.00	1,730,000.00
	Сургалт семинарын зардал	3,044,150.00	
	Төлбөр хураамж, жижиг татварууд	1,247,495.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,730,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,363,213.00	59,455,390.77
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,812,200.00	54,986,262.77
213101	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,812,200.00	54,986,262.77
	Бусад урсгал шилжүүлэг	4,551,013.00	4,469,128.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,551,013.00	4,469,128.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		684,809,425.00	2,424,691,322.63
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(196,750.00)	1,599,000.00
	Хөрөнгийн орлого		1,599,000.00
	Хөрөнгийн зардал		1,599,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр		
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(196,750.00)	1,599,000.00
		(196,750.00)	
ЭХ.ДТ 31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	196,750.00	-
ЭЦ.ДТ 32	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/			
	ЗГ-ын оруулсан капитал /ЗГ-ын сан/, орон нутгийн сан	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	(190,865,499.41)	71,545,906.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	(190,865,499.41)	71,545,906.95
Үндсэн хөрөнгийн өсөлт				
Үндсэн хөрөнгийн бууралт				
Тайлант үеийн үр дүн			522,811,023.19	522,811,023.19
2015 оны 12-р сарын 31 -ээрх үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	331,945,523.78	594,356,930.14

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зардлын хэтрэлт, хэмнэлт	Хувь
I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		218,560,800.00	165,359,459.86	-	#DIV/0!
II. Нийт зарлагын дүн		218,560,800.00	165,359,459.86	53,201,340.14	75.66
III. Урсгал зардлын дүн		218,560,800.00	165,359,459.86	53,201,340.14	75.66
	Бараа үйлчилгээний зардал	192,759,000.0	160,890,331.86	31,868,668.1	83.47
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	131,022,600.00	122,887,926.00	8,134,674.0	93.79
2101	Үндсэн цалин	110,905,600.00	105,446,124.00	5,459,476.0	95.08
2101	Унаа, хоолны хөнгөлөлт	13,522,600.00	10,850,602.00	2,671,998.0	80.24
	Үр дүнгийн урамшил	6,594,400.00	6,591,200.00	3,200.0	99.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,412,500.00	14,412,500.00	-	100.00
2102	Тэтгэврийн даатгал	9,171,600.00	9,171,600.00	-	100.00

2102	Тэтгэмжийн даатгал	1,048,200.00	1,048,200.00	-	100.00
2102	ҮОМШӨ-ний даатгал	1,310,200.00	1,310,200.00	-	100.00
2102	Ажилгүйдлийн даатгал	262,000.00	262,000.00	-	100.00
2102	Эрүүл мэндийн даатгал	2,620,500.00	2,620,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,009,600.00	7,385,742.86	2,623,857.1	73.79
2104	Бичиг хэрэг	1,407,600.00	1,252,900.00	154,700.0	89.01
2104	Тээвэр, шатахуун	4,926,600.00	4,036,784.00	889,816.0	81.94
2104	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,128,000.00	2,041,058.86	1,086,941.1	65.25
2104	Ном авах хэвлэл	391,000.00	55,000.00	336,000.0	14.07
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ажуйн эд зүйлс	156,400.00		156,400.0	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,910,000.00	1,021,000.00	2,889,000.0	26.11
2106	Багаж, техник хэрэгсэл	-	-	-	0.00
2106	Урсгал засвар	3,910,000.00	1,021,000.00	2,889,000.0	26.11
2107	Томилолт, зочны зардал	438,200.00	-	438,200.0	0.00
2107	Дотоод албан томилолт	438,200.00	-	438,200.0	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,251,600.00	13,453,163.00	15,798,437.0	45.99
2108	Төлбөр хураамж болон бусад зардал	29,251,600.00	13,453,163.00	15,798,437.0	45.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,714,500.00	1,730,000.00	1,984,500.0	46.57
2109	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,714,500.00	1,730,000.00	1,984,500.0	46.57
	ТАТААС	25,801,800.00	4,469,128.00	21,332,672.0	17.32
2143	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	25,801,800.00	4,469,128.00	21,332,672.0	17.32
2143	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,207,600.00	-	21,207,600.0	0.00
2143	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	4,594,200.00	4,469,128.00	125,072.0	97.28
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,560,800.00	165,359,459.86	53,201,340.1	75.66
	Бусад орлого	0	1222.63	(1,222.6)	0.00
	Төсвөөс санхүүжих	218,560,800.00	165,358,237.23	53,202,562.8	75.66

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ
АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн			2,206,144,600.00
II. Нийт зарлагын дүн			2,206,144,600.00
III. Урсгал зардлын дүн			2,206,144,600.00
	Бараа үйлчилгээний зардал		2,206,144,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,206,144,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,206,144,600.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			2,206,144,600.00
	Бусад эх үүсвэр		33,560,000.00
	Засаг даргын нөөц хөрөнгө		2,179,561,100.00